

## ГАМШГААС ХАМГААЛАХ СУРТАЛЧИЛГААНЫ УЛСЫН АЛБАНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

### ANALYSIS OF THE CURRENT STATE OF THE PUBLICITY OFFICE OF DISASTER PREVENTION



**Б.Цэнд\***

Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдал-гамшиг судлалын магистрант, ахмад  
Capt. Tsend B, MA Scholar in Emergency-Disaster Studies, University of Internal Affairs

\*Хариуцлагатай зохиогч: b.tsend0606@gmail.com

**Хураангуй:** Улсын хэмжээнд гамшигаас хамгаалах үйл ажиллагааг гурван түвшинд зохион байгуулж байна. Харин хэрэгжүүлэлтийн хувьд Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комисс, Онцгой байдлын байгууллага нь гамшигтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр мэргэжлийн зөвлөгөө, заавар, мэдээ мэдээллээр хангах чиг үүрэгтэйгээс гамшигаас хамгаалах сурталчилгааны албаны үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээ, бүтцийн талаар судалсан судалгааны материал төдийлөн судлагдаагүй байгаа нь анхаарал татах байна.

Иймд энэхүү сэдвийг сонгон, холбогдох эрх зүйн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийж, сайжруулах арга замын талаар саналаа боловсруулан улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй гамшигаас хамгаалах улсын албадын гамшигтай тэмцэх, урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны онцлог, хэрэгжүүлэх чиг үүргийн өнөөгийн байдалд шинжилгээг одоогийн мөрдөгдөж буй эрх зүйн баримт бичигт үндэслэн явууллаа. Цаашид энэхүү салбарын эрх зүйн асуудлыг шийдвэрлэнсээр гамшигаас хамгаалах сурталчилгааны албанд харьяалагдах яам, агентлаг, нийслэл, аймгийн Засаг даргын тамгын газрын хэвлэл мэдээлэл хариуцсан алба, мэргэжилтнүүдийн хамтын ажиллагаа сайжирч, гамшигийн мэдээ, мэдээлэл иргэд, аж ахуйн нэгжид үнэн зөв, шуурхай хүргэгдэх нэгдсэн тогтолцоо бий болох юм.

**Abstract:** Disaster prevention activities are organized at three levels in Mongolia. However, in terms of implementation, it is noteworthy that research materials on the activities, implementation measures, and structure of disaster prevention and awareness-raising services have not been studied much, as the Government of Mongolia, the State Emergency Commission, and the Emergency Management Agency are responsible for providing professional advice, guidance, and information in the field of disaster prevention and control.

Therefore, this paper focuses on an analysis of relevant legal documents regarding the current status of the characteristics and implementation functions of disaster prevention and training, awareness-raising, and implementation of disaster management by state disaster protection agencies nationwide.

By resolving legal issues in this field, the cooperation among personnel in ministries, agencies, the media offices of the capital and Province Governor's Offices with experts affiliated with the disaster prevention and awareness service will be enhanced. A unified system for accurately and promptly delivering disaster news and information to citizens and businesses will be created.

**Түлхүүр үг:** Чиг үүрэг, зохион байгуулалт, дүн шинжилгээ, сайжруулалт

**Keywords:** Functions, organization, analysis and improvement

#### Үндэслэл

Монгол Улсын Засгийн газраас 2015 оны 303 дугаар тогтоолоор баталсан “Гамшигийн эрсдэлийг олон нийтийн

оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр”-т 2023 оны 78 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсантай холбогдуулан тус заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд



МОНГОЛ УСГЫН ХАМГААЛАХ СҮРТАЛЧИЛГААНЫ АЛБАНЫ ЧИГ ҮҮРЭГ

Гамшгаас хамгаалах сурталчилгааны албаны өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийлээ.

Тус хөтөлбөрийн 3.2.9-д "Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээлэл, сургалт, сурталчилгааг сар бүрийн сүүлийн долоо хоногийн пүрэв гарарт тодорхой давтамжтайгаар нийтэд түгээх" хэмээн өөрчлөлт орсон(Монгол Улсын Засгийн газар, 2015).

Түүнчлэн гамшиг, осол, аюул тохиолдсон үед иргэдийг үнэн, зөв мэдээллээр хангах, эрсдэлээс сэргийлэх, зөвлөгөө, мэдээлэл өгөх чиг үүргийг Гамшгаас хамгаалах Сурталчилгааны алба гүйцэтгэхээр дүрэмд тусгасан. Гэвч өнөөг хүртэл шаардлагад нийцэхгүй, үйл ажиллагаа нь тогтмол бус, албаны бүрэлдэхүүний мэдлэг, мэдээлэл дутмаг, харилцаан ажиллагаа хангалтгүй байна.

**Гамшгаас хамгаалах**  
Сурталчилгааны албаны өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, цаашид олон нийтэд мэдээлэл өгөх, шийдвэр гаргах түвшинд анхаарал хандуулах зорилгоор энэхүү өгүүллийг бичихээр зорьсон болно. Тус өгүүллийг бичихдээ Гамшгаас хамгаалах тухай хууль, Гамшгаас хамгаалах улсын албаны нийтлэг журам, Гамшгаас хамгаалах Сурталчилгааны албаны төлөвлөгөөг харьцуулан судаллаа.

Гамшгаас урьдчилан сэргийлэх болон гамшиг, ослын үеийн мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх арга хэмжээ нэгдсэн нэг тогтолцоотой, зохион байгуулах арга замтай байх нь гамшиг, ослын үеийн олон нийттэй харилцах мэдээллийн харилцааны үед үүсэж болзошгүй асуудлаас урьдчилан сэргийлэх, богино хугацаанд хариу арга хэмжээ хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.

#### Үндсэн хэсэг

**Гамшгаас хамгаалах сурталчилгааны албаны эрхзүйн орчин**

Анх гамшгаас хамгаалах албыг БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1967 оны гуравдугаар сарын нэгний өдрийн 42 дугаар "Иргэний хамгаалалтын албадыг байгуулах тогтоол"-оор байгуулж байжээ (Базаррагчаа, 2023).

Гамшгаас хамгаалах албаны үйл ажиллагаа нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйл, Засгийн газрын 2018 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 347 дугаар тушаалаар батлагдсан "Гамшгаас хамгаалах улсын албаны ажиллах нийтлэг журам"-аар тус тус зохицуулагдаж байна.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22.6-д "Салбар дундын гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах, уялдуулан зохицуулах, мэдээ, мэдээлэл солилцох, хүч хэрэгсэл, нөөцийг оновчтой хуваарилах зорилгоор төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, холбогдох бусад байгууллагыг түшиглэн гамшгаас хамгаалах орон тооны бус Улсын албыг Онцгой байдлын байгууллагын Засгийн газрын гишүүн, аймаг, сум, нийслэл, дүүрэгт орон нутгийн албыг тухайн шатны Засаг даргын шийдвэрээр байгуулна" хэмээн заасны дагуу улсын хэмжээнд нийт 12 албыг байгуулж, чиг үүргийг нь тодорхойлсон бөгөөд хуулийн зүйл, заалтад гамшгаас хамгаалах сурталчилгааны албаны чиг үүрэг хэрхэн тусгасан талаар авч үзье.

#### Гамшгаас хамгаалах сурталчилгааны албаны чиг үүрэг

Гамшгаас хамгаалах тухай хуульд анх 2003 онд улсын албадын чиг үүрэг 12 байсан бол 2017 оны шинэчилсэн найруулгаар 15, 2021 оны нэмэлт, өөрчлөлтөөр 16 болгон нэмэгдүүлсэн байна (Ууганбаяр&Чимэдцэрэн, 2023). Гамшгаас хамгаалах Сурталчилгааны улсын албаны чиг үүргийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга даргалж, Засгийн газрын хэрэг эрхлэх газрыг түшиглэн үйл ажиллагааг нь хэрэгжүүлэхээр тусгажээ.

№	Сурталчилгааны албаны чиг үүрэг	Гамшгийн омно	Гамшгийн үед	Гамшгийн дараа
---	---------------------------------	---------------	--------------	----------------



МОНГОЛ УСАГДЫН НАСАНААГАА СУРГААСАН ТАХААРХ НӨХЦӨЛ

1	Гамшгийн тухай зарлан мэдээллийн болон сэрэмжлүүлэг дохио, мэдээллийг дамжуулах арга хэмжээг зохион байгуулах			
2	Гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах арга хэмжээний явц, байдлын тухай мэдээ, мэдээллийг хүн амд тайлбарлан таниулах			
3	Улсын албадаас гамшгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээний тухай бэлтгэсэн ухуулга сурталчилгааг хүн амд шуурхай хүргэх			
4	Засгийн газрын шийдвэрийг нийтэд мэдээлэх			
5	Гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах арга хэмжээний талаарх нөхцөл байдлыг мэдээлэх			
6	Гамшгийн нөхцөл байдлын мэдээлэл цуглуулах			

Хүснэгт-1: “Гамшгаас хамгаалах тухай хууль”-д заасан чиг үүргийг гамшгийн гурван түвшинд авч үзвэл:

Дээрх хүснэгтээс дүгнэхэд Гамшгаас хамгаалах Сурталчилгааны улсын алба нь зургаан чиг үүрэгтэй. Үүнээс урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааг нийтлэгээр зохион байгуулахаар тусгагдсан ч нарийвчилсан болон цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан зайлшгүй авч хэрэгжүүлэх чиг үүргийг тодорхойлоогүй байна.

Харин Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлээс гадна Засгийн газрын 2018 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 347 дугаар тушаалаар батлагдсан “Гамшгаас хамгаалах улсын албаны ажиллах нийтлэг журам”-ын 2.1-т Улсын алба дараах үүргийг хэрэгжүүлэхээр заасан. Эдгээр үүргүүд Гамшгаас хамгаалах Сурталчилгааны албаны төлөвлөгөөнд хэрхэн тусгагданыг хүснэгтээр харууллаа.

№	Албадын үүрэг	Сурталчилгааны албаны төлөвлөгөөнд тусгагдсан байдал
1	Улсын албаны бүрэлдэхүүн, техник, хэрэгслийн бэлэн байдлыг хангах;	Сурталчилгааны улсын алба нь 2018 онд анх Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг батлуулж, 2023 онд шинэчилсэн байна. Тус төлөвлөгөөнд Гамшгаас хамгаалах сурталчилгааны улсын алба нь орон тооны бус штабын томилгоот 7 гишүүн болон бусад ажилтан буюу Засгийн газрын ХМОНХГ 9 мэргэжилтэн нийт 16 хүний бүрэлдэхүүнтэй. Мөн яамд, харьяа газар агентлаг, нийлэлийн ЗДТГ, аймгуудын хэвлэлийн алба, нэгж, МҮОНРТ, гэрээт хэвлэл мэдээллийн байгууллагын хүн, хүч болон явуулын станц, шууд дамжуулалтын төхөөрөмж зэрэг техник хэрэгслийг газар хөдлөлтийн гамшгийн үед мэдээлэл тутгэх, дамжуулахад дайчлан ашиглах боломжтой.
2	Шаардлагатай бол Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, бусад албадтай хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулж, Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр баттуулах;	
3	Гамшгийн эрсдэлийн үнэлгээг эрх бүхий байгууллагаар хийлгэх, үнэлгээнд үндэслэн гамшгийн эрсдэлийг	Гамшгаас хамгаалах сурталчилгааны улсын албаны байр буюу Төрийн ордон нь Улаанбаатар хотын төв хэсэгт байрладаг учир зам, харилцаа холбоо, дулаан хангамж зэрэг дэд бүтэц сайн хөгжсөн. Гамшиг, ослын үед аврах анги,



МОНГОЛ УСГЫН ТӨВӨЛӨҮҮСНӨЙН СҮРТЭН ЧИЛГИЛГҮҮД

	бууруулах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, мэдээ, тайлан гаргах;	шуурхай албаны машин ирэхэд саадгүй. Мөн дөрвөн давхар буюу харьцангуй намхан, ойролцоо өндөр барилга цөөн, Сүхбаатарын талбай зэрэг сул талбай ихтэй, аюул, ослын үеийн гарц тодорхой. НОБГ-ын Төрийн ордны Онцгой байдлын албанаас гамшигийн бэлэн байдлыг хангах, гамшигийн үед албан хаагчдыг чиглүүлэх, удирдан зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх боломжтой.
4	Гамшигаас хамгаалах чиглэлээр тушаал, албан даалгавар, удирдамж гаргах, биелэлтийг шалгах, салбарын хүрээнд баримтлах дүрэм, журам, заавар боловсруулж батлах, хэрэгжүүлэх	
5	Засгийн газар, Улсын онцгой комисс, Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захирагааны байгууллагыг мэргэжлийн зөвлөгөө, заавар, мэдээ мэдээллээр шуурхай хангах;	-Гамшигаас хамгаалах талаарх төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр, хууль, тогтоомжийг хэрэгжилтийг сурталчлах, -Газар хөдлөлтийн гамшиг тохиолдож онц байдал тогтоосон үед хэвлэл мэдээллийн байгууллагад мэдээллийг нэг урсгалаар хүргэх -Гамшигийн үеийн авран хамгаалах ажиллагаа болон гамшигийн дараах сэргээн босголтын үед иргэд, олон нийтийг цаг үеийн мэдээллээр түргэн шуурхай хангах
6	Гамшиг болон аюулт үзэгдэл, ослын үед салбарыг ажлын тусгай горим болон гамшигаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, гамшигийн голомтын бүсэд хүч хэрэгслийг шуурхай томилон ажиллуулах;	Хэвлэл мэдээлэл хариуцсан удирдлага, ажилтнуудыг харьяа салбар, чиглэлээр нь мэдээлэл сурталчилгаа бэлтгэх, түгээх үйл ажиллагаанд дайчлан ажиллуулна.
7	гамшигийн голомтод үүрэг гүйцэтгэх албан хаагчдыг шаардагдах техник, материал хэрэгслээр хангах, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх.	Гамшигаас хамгаалах сурталчилгааны албаны үйл ажиллагааны онцлогт тохирсон <b>тусгай тохөөрөмж нийслэлд 3, аймагт 4</b> байна. Үүнд: -Дрон - “Монголын төмөр зам” ХХК, БХЯ-ны дэргэдэх “Соёмбо” редакц, Говь-Алтай, Завхан, Хөвсгөл аймгийн Хэвлэл мэдээлэл хариусан алба, нэгжид тус бүр нэг; -Шууд дамжуулалтын тохөөрөмж - ХХЕГ-ын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба, Баян-Өлгий аймгийн Төрийн үйлчилгээ мэдээлэлийн төвд тус бүр нэг байна.

Хүснэгт-2: “Гамшигаас хамгаалах улсын албаны ажиллах нийтлэг журам”-д заагдсан үүргийн хэрэгжилт

Дээрх хүснэгт 2-ыг дүгнэж үзвэл Гамшигаас хамгаалах Сурталчилгааны алба нь төлөвлөгөөгөө боловсруулахдаа газар хөдлөлт болсон тохиолдолд ажиллах хүн, хүчний судалгааг гаргаж, эрсдэлийн үнэлгээг хийлгэсэн нь бусад төрлийн гамшиг, ослын үед нэгдсэн зохион байгуулалттай ажиллах чиг үүрэг тодорхой бус. Албаны бүрэлдэхүүн буюу харьяа агентлаг, байгууллагуудын уялдаа холбоог хэрхэн хангах, хамтран ажиллах талаар заалт тусгаагүй байгаа зэрэг нь цаг, үеийн шаардлага, нөхцөл байдалтай уялдуулан төлөвлөгөөгөө шинэчлэх, чиг, үүргийг

нарийвчлан тусгах шаардлагатай байна гэж үзэж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 416 дугаар тушаалаар батлагдсан “Гамшигийн аюулаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгот арга хэмжээний Монгол Улсын төлөвлөгөө”-д байгууллага хоорондын уялдаа холбоог хэрхэн хангах, гамшигаас хамгаалах албадын харилцан ажиллагааны зохицуулалтыг тусгасан байдаг.



МОНГОЛ УИГҮҮРНИЙ СУРТALЧИ  
МОНГОЛ УИГҮҮРНИЙ СУРТALЧИ  
МОНГОЛ УИГҮҮРНИЙ СУРТALЧИ

№	Аюулт үзэгдэл, ослын төрөл	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Удирдан зохион байгуулах	Дэмжлэг үзүүлэх	Сурталчилгааны улсын албандаа хамаарах эсэх
1	Газар хөдлөлт	Хүчтэй газар хөдлөлт болсон үед иргэдэд гамшигийн аюулыг амжиж анхааруулах (Улаанбаатар хотоос 200-400 км тойротг хүчтэй газар хөдлөлт болсон тохиолдолд)	ОБЕГ	ООГХ, хэвлэл мэдээллийн байгууллага, үүрэн холбооны оператор	-
		Иргэдэд гамшигийн тухай мэдээлэл хүргэх, дахин болж болзошгүй газар хөдлөлт болон гамшигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сэргээжлүүлэх	ОБЕГ	ООГХ, хэвлэл мэдээллийн байгууллага, үүрэн холбооны оператор	-
2	Хүний гоц халдварт өвчин	Хэвлэл мэдээллийн байгууллагаар зарлан мэдээлэх, сэргээжлүүлэг мэдээлэл хүргэх	УОК	ЭМСЯ, ОБЕГ, МХЕГ, ЦЕГ, ТЕГ, НЗБ	+
		Гамшигийн нөхцөл байдлын талаарх мэдээллээр хангах	ЗГ-ЫН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ АЛБА	МТШХХГ, ОБЕГ, МХЕГ	
3	Ган	-	-	-	-
4	Зуд	Зудын байдлын талаар мэдээлэл хүргэх	УОК, ХХААЯ	МТШХХГ, ОБЕГ, ЦУОШГ	-
5	Хүчтэй цасан болон широон шуурга	Гамшигийн нөхцөл байдлын талаарх мэдээллээр хангах	ЗГ-ЫН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ АЛБА	БОНХАЖЯ, ХХААЯ, НЗБ	+
6	Үер	Гамшигийн нөхцөл байдлын талаарх мэдээллээр хангах	ШШ	ЗГ-ЫН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ АЛБА	+
7	Мал, амьтны гоц халдварт өвчин	Гамшигийн нөхцөл байдлын талаарх мэдээллээр хангах	ЗГ-ЫН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ АЛБА	МТШХХГ, ОБЕГ, МХЕГ	+
8	Ой, хээрийн гал түймэр	Гамшигийн нөхцөл байдлын талаарх мэдээллээр хангах	УОК, ОБЕГ	БОНХАЖЯ, МТШХХГ, ЦУОШГ, НЗБ	-
9	Объектын гал түймэр	-	-	-	-



10	Химиийн хорт болон аюултай бодис, цацраг, цацраг идэвхт бодис алдагдах	-	-	-	-
----	--	---	---	---	---

Хүснэгт-3: Дээрх журамд зааснаар аюулт үзэгдэл, осол тохиолдсон үед Гамшигаас хамгаалах Сурталчилгааны албаны оролцоо хэр байгааг авч үзэхэд:

Дээрх 10 төрлийн аюул, осол тохиолдсон үед Сурталчилгааны алба хэрхэн дэмжлэг үзүүлэн ажиллах талаар ерөнхийд нь дүгнэхэд, мал, амьтны болон хүний гоц халдварт өвчин, хүчтэй цасан болон шороон шуурга, үерийн үед ажиллахаар тодорхойлсон байна. Бусад тохиолдолд УОК, ОБЕГ удирдан чиглүүлэхээр тусгажээ.

### Гамшигаас хамгаалах улсын албадын болон сурталчилгааны албаны штабын бүтэц

“Гамшигаас хамгаалах улсын албаны ажиллах нийтлэг журам”-д дараах байдлаар Улсын албаны удирдлага буюу штабын бүрэлдэхүүнийг тодорхойлсон.

ГАМШИГААС ХАМГААЛАХ УЛСЫН АЛБАНЫ УДИРДЛАГА (ШТАБ)-ЫН БҮРЭЛДЭХҮҮН



Зураг-1. Гамшигаас хамгаалах улсын албаны удирдлага, бүрэлдэхүүнийг харуулсан зураглал


Харин Гамшигаас хамгаалах Сурталчилгааны албаны төлөвлөгөөнд сурталчилгааны ажлын албаны дарга нь Засгийн газрын эрхлэх газрын дарга, штабын даргаар Засгийн газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газрын дарга байна. Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 475 дугаар тогтооюор Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын бүтцэд Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газар хамаардаг болсон. Тус газар нь үг, илтгэлийн хэлтэс, цахим мэдээллийн хэлтэс, сонин, хэвлэлийн хэлтэс, контент боловсруулах хэлтэс, гадаад, мэдээ, сурталчилгааны хэлтэс, иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв гэсэн бүтэцтэйгээр үйл ажиллагаа явуулж

байна. Түүнээс гадна сайд, яамдын Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн дарга нар, Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн удирдлага, холбогдох байгууллага, түүний удирдлага болон хэвлэл мэдээллийн байгууллага, Хэрэг эрхлэх газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, сайд нарын хэвлэлийн төлөөлөгчид хамаардаг юм.

Гамшигаас хамгаалах Сурталчилгааны улсын албаны төлөвлөгөөг Монгол Улсын Шадар сайдын 2013 оны 52 дугаар тушаалын дагуу 2018 онд боловсруулсан бол 2023 онд шинэчлэн баталсан ч чиг үүрэг, үйл ажиллагаанд өөрчлөлт ороогүй зөвхөн баталсан албан тушаалтан, дарга нь солигдсон байна.



МОНГОЛ УСАГДЫН НАСАНААГАА СУРГАЛЧИЛГААНЫ УЛСЫН АЛБАНЫ ШТАБЫН БҮТЭЦ



Зураг-2. Гамшигийн хамгаалах Сурталчилгааны улсын штабын бүтцийг харуулсан зураглал

Гамшигийн хамгаалах Сурталчилгааны улсын албаны Гамшигийн хамгаалах бэлэн байдлын үзлэгийг МҮОННРТ-д 2019 онд зохион байгуулсан байна. Тус үзлэгээр Гамшигийн хамгаалах Сурталчилгааны улсын алба, Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн гамшигийн хамгаалах төлөвлөгөөтэй танилцахад Засгийн газрын 2018 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Гамшигийн хамгаалах улсын албаны ажиллах нийтлэг журам”-ын 1.3, 2.1.4-т зааснаар штаб байгуулсан тушаал гаргаагүй, гамшигийн урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах болон сэргээн босгох, нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааны чиглэлээр төлөвлөгөөтэй, Гамшигийн хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2-т заасан гамшигийн хамгаалах асуудал хариуцсан орон тооны албан хаагч томилоогүй, гамшигийн хамгаалах мэдээлэл сурталчилгааны тусгай зориулалтын мэргэжлийн ангийн төлөвлөгөөг байгууллагын гамшигийн хамгаалах төлөвлөгөөтэй хамтатган боловсруулсан зэрэг дутагдалтай байна (ОБЕГ, 2019). Үүнээс хойш өнөөг хүртэл буюу таван жилийн хугацаанд бэлэн байдлын үзлэгийг зохион байгуулаагүй байна.

### Дүгнэлт

Тохиолдож болзошгүй аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эрсдэлийг бууруулах, аврах, хор уршгийг арилгах,

хойшилуулшгүй сэргээн босгох арга хэмжээг эрхэлсэн салбарын хэмжээнд олон нийтэд сурталчлан таниулах зорилготой Гамшигийн хамгаалах Сурталчилгааны албаны Гамшигийн хамгаалах хуулийн хүрээнд хэрэгжүүлэх чиг үүрэг хангалтгүй байна.

Чиг үүргийн дагуу ажиллах бэлтгэл, бэлэн байдал хэр хангагдсан нь тодорхой бус буюу хэрэгжүүлэх холбогдох дүрэм, журам, зааврыг холбогдох байгууллагаар батлуулаагүй.

Гамшигийн гурван шатанд болоод Монгол оронд зонхилон тохиолддог аюулт үзэгдэл, ослын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг нарийвчлан гаргаагүй буюу тодорхой бус байна.

Гамшигийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл, Онцгой комиссын хурал, үйл ажиллагаанд тогтмол төлөөллөө оролцуулдаг ч авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ нь дутмаг буюу хангалтгүй.

Сурталчилгааны албаны хамгаалах чиг үүрэг, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар ажилтан, алба хаагчид нь мэдээлэлгүй байна. Мөн салбарын онцлогт нийцүүлэн гамшигийн хамгаалах албаны бүрэлдэхүүнийг тогтоох, мэргэжлийн ангийг байгуулах, сургалт, дадлагыг зохион байгуулаагүй байна.

### Гамшигийн хамгаалах

Сурталчилгааны албаны чиг үүргийг тодорхойлохдоо цаг үеийн нөхцөл байдалтай нийцээгүй буюу гамшиг, ослын төрөл бүрт хэрэгжүүлэх арга хэмжээ



МОНГОЛ УСЫН ХУУЛЬ САХИУЛАХАЙ

байхгүй байгаа нь байгууллага хоорондын уялдаа холбоог хангах нөхцөл бүрдэхгүй байна.

Гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг тухайлсан салбарууд өөрийн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлдэг ч нэгдсэн зохион байгуулалт, удирдлага, зөвлөн туслах үйлчилгээ дутмаг байна.

### Санал

Улсын болон аймаг, дүүргийн Гамшгаас хамгаалах сурталчилгааны албаны төлөвлөгөөг цаг, үеийн нөхцөл байдалтай холбогдуулан шинэчлэх, авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой болгох.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 5.1-т заасны дагуу гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилтийг төсөвлөж зарцуулаад бодлогоор дэмжих.

Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг тогтмол зохион байгуулж, гамшгаас хамгаалах асуудал хариуцсан орон тооны албан хаагчийг томилж, үйл ажиллагааг нь идэвхжүүлэх, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн, ажилтан, албан хаагчдын гамшгийн үед ажиллах мэдлэг дадлагыг дээшлүүлэх сургалт дадлагыг тогтмолжуулах.

Олон улсын туршилага, аргазүйгээс суралцах, өөрийн орны онцлог, үйл ажиллагаа, хэвлэл мэдээллийн хэрэгслийн өнөөгийн байдалд тулгуурлан нэвтрүүлэх, түүнийг хэрэгжүүлэх боловсон хүчинийг үе шаттгайгаар сургаж, дадлагажуулах.

Гамшгийн эрсдэлийг буруулах үндэсний болон орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагаанд тогтмол хэрэгжүүлэх үйл ажиллагааг тусгах. Саналыг хэрэгжүүлэхэд бодлогоор дэмжих.

Гамшгаас хамгаалах сурталчилгааны албаны үйл ажиллагаагаар дамжуулан олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, иргэдийг сургаж, дадлагажуулах.

Олон нийтэд зориулсан танин мэдэхүйн урьдчилан сэргийлэх арга хэмжээ, зөв дадал, зурсилтай болгох үзэлд төлөвшүүлэх аян, арга хэмжээг улс орон даяар зохион байгуулах.

Олон улсад ашиглаж байгаа гамшиг, ослын үеийн эрсдэлийн мэдээллийн харилцааг нэвтрүүлж, хэрэгжүүлэх үйл ажиллагааг өөрийн орны онцлогт тохицуулан нутагшуулах.

Гамшиг, осол тохиолдсон үед байгуулагдан ажиллаж байгаа “УОК-ын Шуурхай штаб”-ын бүрэлдэхүүнд Гамшгаас хамгаалах улсын албыг татан оролцуулах, хамтран ажиллах бүтцийг бий болгох шаардлагатай байна.

### Ашигласан материал

Монгол Улсын Их Хурал. (2017). Гамшгаас хамгаалах тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017(18).

Улаанбаатар.

Монгол Улсын Засгийн газар. (2018). Гамшгаас хамгаалах улсын албаны ажиллах нийтлэг журам (347-р тогтоол). Улаанбаатар.

Монгол Улсын Засгийн газар. (2015). Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уригийг арилах, хойшлуулсгүй сэргээн босгох арга хэмжээний Монгол Улсын төлөвлөгөө (416-р тогтоол). Улаанбаатар.

Онцгой байдлын ерөнхий газар. (2018, 2023). Сурталчилгааны ажлын төлөвлөгөө. Улаанбаатар.

Онцгой байдлын ерөнхий газар. (2019). Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг зохион байгуулсан тухай илтгэх хуудас. Улаанбаатар.

Базаррагчаа, С. (2023). Гамшгийн эрсдэлийн удирдлага (Гарын авлага).

Ууганбаяр, Б., & Чимэдцэрэн, П. (2023). Газар хөдлөлтийн гамшгийн үеийн удирдлага, зохицуулалтын өнөөгийн байдалд хийсэн шинжилгээ. Гамшиг судлал инновац сэтгүүл, 2023(1).